ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ЗАА-2025/045/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум 2026 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Аудитор: О.Алтансувд

Утас: 88009224

Цахим хаяг: altansuvdoyu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улиастай, Завхан аймаг 81090
Утас/Факс: 7046-36-12
Имэйл: [illegible]

2026.02.02 № 39

танай ______ -ны № ______ -т

БАЯНХАЙРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Х.ОЮУНЧИМЭГ-Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газарт тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 12,900.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 8,185.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 27,781.0 мянган төгрөгийн хөрөнгө нийлүүлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар Засаг даргын нөөц хөрөнгөөс 2 иргэнд гэр худалдаж авахад дэмжлэг үзүүлж 2,500,000 төгрөгийг гаргаж батлагдсан төсвийг үр ашиггүй үрэлгэн, зориулалт бусаар зарцуулсан. Өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчид 750,000 төгрөгийн тэтгэмж давхардуулж, мөн орон тооны цомхотголоор ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчид 315,000 төгрөгийн тэтгэмж, орон тооны цомхотголоор хасагдсан орон тоонд ажил хавсарсан нэмэгдэл 40 хувийн 817,528.0 мянган төгрөгийн цалин тус тус илүү олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Баянхайрхан сумын Засаг даргын Тамгын газар нь Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл болон журналаас анхан шатны баримт руу хөөн шалгахад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 239,515.7 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-ҮНДРАА

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **72,912,893.36** | **68,222,245.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 72,912,893.36 | 68,222,245.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 1,403,500.00 | 1,403,500.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,403,500.00 | 1,403,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 65,809,393.36 | 61,118,745.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,000,040.00 | 2,868,320.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,260,600.00 | 3,047,100.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | 80,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 8,098,253.36 | 924,825.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 53,450,500.00 | 54,198,500.00 |
| 35600 | Мал амьтад | 5,700,000.00 | 5,700,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,154,782,075.02** | **1,079,770,914.13** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,154,782,075.02 | 1,079,770,914.13 |
| 39100 | Газар | 8,620,000.00 | 8,620,000.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,138,901,811.86 | 1,059,934,112.16 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 537,632,139.00 | 537,632,139.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (101,324,549.39) | (128,463,068.21) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 414,673,865.00 | 414,673,865.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (138,101,111.36) | (160,097,751.76) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж, компьютер | 238,820,242.00 | 269,952,520.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (65,412,781.75) | (108,168,075.13) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 13,696,400.00 | 24,717,500.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (6,196,426.42) | (7,101,086.29) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 34,179,103.00 | 34,179,103.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (11,361,317.26) | (14,545,707.77) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 3,660,000.00 | 3,660,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 457,446,922.00 | 457,446,922.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (238,810,672.96) | (263,952,247.68) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 7,260,263.16 | 11,216,801.97 |
| 39301 | Програм хангамж | 3,077,000.00 | 2,697,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,665,316.84) | (2,525,941.84) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 6,848,580.00 | 11,304,580.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | (258,836.19) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,227,694,968.38** | **1,147,993,159.13** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | **1,029,982.18** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 1,029,982.18 |
| **413** | **Өглөг** | - | 1,029,982.18 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 796,482.18 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 233,500.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,227,694,968.38** | **1,146,963,176.95** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,227,694,968.38 | 1,146,963,176.95 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/орон нутгийн сан | 279,825,085.40 | 279,825,085.40 |
| 51101 | Өмч: - төрийн | 279,825,085.40 | 279,825,085.40 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 776,247,317.73 | 695,515,526.30 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 422,467,317.31 | 776,247,317.73 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 353,780,000.42 | (80,731,791.43) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 171,622,565.25 | 171,622,565.25 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,227,694,968.38** | **1,147,993,159.13** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Данс ны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **1,345,707,118.00** | **930,128,284.10** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **454,796,260.00** | **28,991,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 454,796,260.00 | 28,991,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 450,221,360.00 | 27,781,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 4,574,900.00 | 1,210,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **890,910,858.00** | **901,137,284.10** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 163,162,458.00 | 30,332,084.10 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 15,675,799.10 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 148,162,458.00 | 12,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,000,000.00 | 2,656,285.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 727,748,400.00 | 870,805,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 727,748,400.00 | 870,805,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **991,927,117.58** | **1,010,860,075.53** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **991,927,117.58** | **1,010,860,075.53** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 922,820,895.55 | 847,923,887.08 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 507,107,426.89 | 542,759,417.89 |
| 210101 | Үндсэн цалин | 314,533,008.21 | 328,296,814.89 |
| 210102 | Нэмэгдэл | 173,080,668.68 | 178,206,631.00 |
| 210104 | Урамшуулал | 19,493,750.00 | 29,776,800.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 6,479,172.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 63,754,293.42 | 67,289,736.75 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,216,331.38 | 45,502,345.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,084,274.06 | 5,354,083.95 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,776,002.22 | 3,014,732.48 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,535,537.22 | 2,627,540.96 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,142,148.54 | 10,791,033.52 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,633,905.66 | 20,686,905.49 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,429,605.66 | 4,934,509.49 |
| 210302 | Түлш, халаалт | 15,204,300.00 | 15,752,396.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 41,129,675.00 | 57,357,212.56 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,855,790.00 | 2,080,220.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,777,290.00 | 38,667,732.56 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,418,095.00 | 4,104,560.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 12,504,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,194,400.00 | 11,394,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 22,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,194,400.00 | 11,372,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 11,410,100.00 | 7,365,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,410,100.00 | 7,365,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 56,094,071.00 | 1,258,449.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 54,581,850.00 | 907,667.50 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469,100.00 | 143,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 727,700.00 | 207,682.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 223,497,023.58 | 139,813,164.89 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 74,605,000.00 | 15,866,004.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 300,000.00 | 70,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 148,592,023.58 | 123,877,160.89 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 69,106,222.03 | 162,936,188.45 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 42,686,468.00 | 51,386,585.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 3,630,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 11,248,100.00 | 38,336,585.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 31,438,368.00 | 7,920,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,500,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 26,419,754.03 | 110,439,258.46 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 26,371,754.03 | 103,264,024.53 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 48,000.00 | 7,175,233.93 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 1,110,344.99 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,110,344.99 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **353,780,000.42** | **(80,731,791.43)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **890,910,858.00** | **901,137,284.10** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **890,910,858.00** | **901,137,284.10** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 163,162,458.00 | 30,332,084.10 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 15,675,799.10 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 148,162,458.00 | 12,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,000,000.00 | 2,656,285.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 727,748,400.00 | 870,805,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 727,748,400.00 | 870,805,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **842,880,858.00** | **880,052,284.10** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **842,880,858.00** | **880,052,284.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **773,774,635.97** | **717,116,095.65** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 507,107,427.05 | 541,529,037.35 |
| 210101 | Үндсэн цалин | 314,533,008.37 | 331,654,445.08 |
| 210102 | Нэмэгдэл | 173,080,668.68 | 177,652,588.44 |
| 210104 | Урамшуулал | 19,493,750.00 | 28,910,831.83 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 3,311,172.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 63,754,293.26 | 67,723,635.11 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,216,331.38 | 46,158,004.21 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,084,273.90 | 5,298,643.95 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,776,002.22 | 2,987,012.48 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,535,537.22 | 2,599,820.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,142,148.54 | 10,680,153.52 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,633,905.66 | 20,686,905.49 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,429,605.66 | 4,934,509.49 |
| 210302 | Түлш, халаалт | 15,204,300.00 | 15,752,396.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 29,554,723.00 | 25,098,091.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,292,200.00 | 1,715,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,844,428.00 | 19,278,531.60 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,418,095.00 | 4,104,560.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,408,680.00 | 4,772,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 224,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,408,680.00 | 4,548,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 11,410,100.00 | 7,365,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,410,100.00 | 7,365,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 76,769,071.00 | 1,283,449.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 75,243,850.00 | 932,667.50 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469,100.00 | 143,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 727,700.00 | 207,682.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 58,136,436.00 | 48,657,776.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 57,836,436.00 | 48,522,776.60 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 300,000.00 | 135,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **69,106,222.03** | **162,936,188.45** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 42,686,468.00 | 51,386,585.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 3,630,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 11,248,100.00 | 38,336,585.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 31,438,368.00 | 7,920,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,500,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 26,419,754.03 | 110,439,258.46 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 26,371,754.03 | 103,264,024.53 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 48,000.00 | 7,175,233.93 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 1,110,344.99 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,110,344.99 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **48,030,000.00** | **21,085,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **48,030,000.00** | **21,085,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **48,030,000.00** | **21,085,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 48,030,000.00 | 21,085,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 48,030,000.00 | 21,085,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(48,030,000.00)** | **(21,085,000.00)** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 1 сарын 1-нээрх үлдэгдэл** | 279,825,085.40 | 171,622,565.25 | 422,467,317.31 | 873,914,967.96 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **279,825,085.40** | **171,622,565.25** | **422,467,317.31** | 873,914,967.96 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 353,780,000.42 | 353,780,000.42 |
| C08 | **2024оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл** | **279,825,085.40** | **171,622,565.25** | **776,247,317.73** | 1,227,694,968.38 |
| D01 | **2025оны 1 сарын 1-нээрх үлдэгдэл** | **279,825,085.40** | **171,622,565.25** | **776,247,317.73** | 1,227,694,968.38 |
| D02 | НБББ-ын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **279,825,085.40** | **171,622,565.25** | **776,247,317.73** | 1,227,694,968.38 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -80,731,791.43 | -80,731,791.43 |
| D09 | **2025 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл** | **279,825,085.40** | **171,622,565.25** | **695,515,526.30** | 1,146,963,176.95 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,018,989,400.58 | 767,541,175.47 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,018,989,400.58 | 767,541,175.47 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 962,112,000.58 | 716,154,590.47 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 559,701,800.58 | 535,802,877.35 |
| 210101 | Үндсэн цалин | 317,490,800.58 | 329,239,457.08 |
| 210102 | Нэмэгдэл | 214,176,700.00 | 177,652,588.44 |
| 210104 | Урамшуулал | 28,034,300.00 | 28,910,831.83 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 72,544,100.00 | 66,832,635.11 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 49,330,000.00 | 45,552,124.21 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,803,500.00 | 5,227,363.95 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,901,800.00 | 2,947,412.48 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,901,800.00 | 2,568,140.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,607,000.00 | 10,537,593.52 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,240,700.00 | 19,202,659.41 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,473,800.00 | 3,450,263.41 |
| 210302 | Түлш, халаалт | 15,766,900.00 | 15,752,396.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,481,400.00 | 18,726,660.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,999,900.00 | 1,715,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,794,300.00 | 12,907,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,687,200.00 | 4,104,560.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 25,480,700.00 | 24,287,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,000,000.00 | 12,244,000.00 |
| 210602 | Тавилга | - | 7,495,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,480,700.00 | 4,548,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 7,365,000.00 | 7,365,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,365,000.00 | 7,365,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,012,300.00 | 709,782.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,400,000.00 | 359,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469,100.00 | 143,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 727,700.00 | 207,682.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 249,286,000.00 | 43,227,776.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 247,936,000.00 | 43,092,776.60 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,350,000.00 | 135,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 56,877,400.00 | 51,386,585.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 56,877,400.00 | 51,386,585.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 7,259,900.00 | 3,630,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 38,698,500.00 | 38,336,585.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 7,920,000.00 | 7,920,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,999,000.00 | 1,500,000.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **22,046,505.18** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **22,046,505.18** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 22,046,505.18 |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 0.00 | 5,726,160.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 2,414,988.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 3,311,172.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 0.00 | 891,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 605,880.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 71,280.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 39,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 31,680.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 142,560.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 0.00 | 1,484,246.08 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 1,484,246.08 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 6,371,431.60 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 6,371,431.60 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 0.00 | 573,667.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 573,667.50 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 7,000,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 7,000,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 22,046,505.18 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 22,046,505.18 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 8,792,959.10 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 10,597,261.08 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 2,656,285.00 |

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 261,378.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 13,076.2 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 1,882.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,500.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 243,920.2 мянган төгрөгийн 2 заалт зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн.

***Залруулсан алдаа:***

Тайлант онд Мөнгөн гүйлгээний тайланд орлого болон зардлыг 4,983.2 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн, санхүүгийн үр дүнгийн тайланд зардлын эдийн засгийн ангилал зөрүүтэй илэрхийлсэн 8,093.0 төгрөгийн алдааг залруулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-тай нийцэхгүй, толилуулга, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**3.1 Төлбөрийн акт**

Орон тооны цомхотголоор хасагдсан орон тоонд ажил хавсарсан нэмэгдэл 40 хувийн цалин тооцож, 817,528 төгрөг олгосон, Өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчид 750,000 төгрөгийн тэтгэмж давхардуулж олгосон, мөн орон тооны цомхотголоор ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчид 315,000 төгрөгийн тэтгэмж илүү тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

**3.2 Албан шаардлага**

Засаг даргын нөөц хөрөнгөөс 2 иргэнд гэр худалдаж авхад дэмжлэг үзүүлж 2,500,000 төгрөгийг гаргаж батлагдсан төсвийг үр ашиггүй үрэлгэн, зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага өглөө.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***__Илрүүлэлт__***: E-mongolia нэмэгдлийг батлагдсан төсвийн хүрээнд олгоогүй, 40 хувиар тооцож, 4,404.4 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2-т "бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***__Өгсөн зөвлөмж__***: E-mongolia нэмэгдлийг батлагдсан төсвийн хүрээнд 20 хувиар тооцож олгох;

***2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***__Илрүүлэлт__***: Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл болон журналаас анхан шатны баримтыг хөөн шалгахад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 239,515.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-д "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

***__Өгсөн зөвлөмж__***: Цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэлж, ашиглалтын хугацааг сунгах, ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох эрх бүхий байгууллагад уламжлан данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

**Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.**

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мөнгөн гүйлгээний тайланд орлого,зарлагын гүйлгээг дутуу бүртгэсэн. | 1 | 4,983.2 | | | 1 | 4,983.2 | 1 | 4,983.2 | | | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд зардлын эдийн засгийн ангилал буруу бүртгэсэн. | 1 | 8,093.0 | | | 1 | 8,093.0 | 1 | 8,093.0 | | | | |
| **Дүн** | **2** | **13,076.2** | | | **2** | **13,076.2** | **2** | **13,076.2** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Орон тооны цомхотголоор хасагдсан орон тоонд ажил хавсарсан нэмэгдэл 40 хувийн цалин тооцож, 817,528 төгрөг олгосон байна. | 1 | 817.5 | 1 | 817.5 | | | | | | | | |
| Өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчид 750,000 төгрөгийн тэтгэмж давхардуулж олгосон, мөн орон тооны цомхотголоор ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчид 315,000 төгрөгийн тэтгэмж илүү тооцож олгосон байна. | 1 | 1,065.0 | 1 | 1,065.0 | | | | | | | | |
| Засаг даргын нөөц хөрөнгөөс 2 иргэнд гэр худалдаж авхад дэмжлэг үзүүлж | 1 | 2,500.0 | | | 1 | 2,500.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2,500,000 төгрөгийг гаргаж батлагдсан төсвийг үр ашиггүй үрэлгэн, зориулалт бусаар зарцуулсан байна. | | | | | | | | | | | | |
| Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл болон журналаас анхан шатны баримт руу хөөн шалгахад элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 239,515.7 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. | 1 | 239,515.8 | | | | | 1 | 239,515.8 | | | | |
| E-mongolia нэмэгдлийг батлагдсан төсвийн хүрээнд олгоогүй, 40 хувиар тооцож, 4,404.4 мянган төгрөгийг илүү олгосон байна. | 1 | 4,404.4 | | | | | 1 | 4,404.4 | | | | |
| **Дүн** | **5** | **248,302.7** | **2** | **1,882.5** | 1 | 2,500.0 | **2** | **243,920.2** | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР

Огноо: 2026-02-03

**БОЛОВСРУУЛСАН:**

АУДИТОР О.АЛТАНСУВД

Огноо: 2026-02-03